PREMIUM
Building Materials

ПРЕМИУМ БЬЮЛДИНГ
МАТЕРИАЛС ХХК

Улаанбаатар хот 14241, Сүхбаатар дүүрэг
1 дүгээр хороо, Олимпийн гудамж 19А, Шангри-Ла Төв
Шангри-Ла Оффис, 23 дугаар давхар, УБД 9011720047

(976) 7777-3311 info@premiumbm.mn

2023.12.13 № 1/518

Танай ____________-ны № ________________-т

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
ЯАМНЫ ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧИН, БАЙГАЛИЙН
НӨӨЦИЙН УДИРДЛАГЫН ГАЗАРТ

Хянан баталгаа хийлгүүлэх хүсэлт

Премиум Бьюлдинг Материалс ХХК нь Нийслэлийн Баянгол дүүрэг, 20-р хороо, Үйлдвэрийн баруун бүс /16103/, Эрчим хүчний гудамж 57/1 тоотод бетон зуурмагийн үйлдвэр №1, Баянзүрх дүүрэг, 10-р хороо Улиастайн гудамж 101/А тоотод бетон зуурмагийн үйлдвэр №2 төслийн үйл ажиллагааг эрхлэн явуулдаг бөгөөд дээрх төслүүдийн 2024 оны Байгаль орчны сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөг хүлээн авч хянан баталж өгнө үү.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ А. ГАНБОЛД

Батлав: БОАЖЯ-ны ХБОБНУГ-ын дарга: ................................ /..................................... /

Зөвшөөрч хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн: Премиум Бьюлдинг Материалс ХХК –н

Гүйцэтгэх захирал: А.ГАНБОЛД

НИЙСЛЭЛИЙН БАЯНГОЛ ДҮҮРЭГ 20 ДУГААР ХОРОО БЕТОН ЗУУРМАГ ҮЙЛДВЭР №1, БАЯНЗҮРХ ДҮҮРЭГ 10 ДУГААР ХОРООНЫ НУТАГ ДЭВСГЭРТ БАЙРЛАХ БЕТОН ЗУУРМАГИЙН ҮЙЛДВЭР №2 НЭРТЭЙ ТӨСЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ

# ПРЕМИУМ БЬЮЛДИНГ МАТЕРИАЛС ХХК –Н 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТ ТӨЛӨВЛӨГӨӨ

Хянасан: БОАЖЯ-ны ХБОБНУГ-ын мэргэжилтэн: ............................../............................ /

Khasbaatar Ganbold Digitally signed by Khasbaatar Ganbold DN: cn=Khasbaatar Ganbold, o=Head of HSE Department, ou=HSE Department, email=khasbaatar@premiumbm.mn, c=MN Date: 2023.12.13 08:32:26 +08'00'

Боловсруулсан: ХАБЭА,БО менежер: Г.ХАСБААТАР / ............................................ /

2024 он

## Нэг. Төслийн товч танилцуулга

“Премиум Бьюлдинг Материалс” ХХК нь 2011 онд Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 20-р хороо, Үйлдвэрийн баруун бүс /16103/, Эрчим хүчний гудамж 57/1 тоотод олон улсын NRMCA-ийн сертификат бүхий “ZOOMLION-CIFA” бетон зуурмагийн үйлдвэрийг, 2017 онд хүчин чадал нэмэгдүүлэх зорилгоор IMER иж бүрэн автомат үйлдвэрийг нэмж ашиглалтад оруулан үйл ажиллагаа явуулж байна. Улаанбаатар хотын баруун хэсэгт /ТЭЦ4- ийн зүүн урд/ байрлах тус үйлдвэрүүд нь C50 (M600) хүртэлх маркийн бетоныг цагт 120 м3 үйлдвэрлэх хүчин чадалтай.
Мөн нийслэлийн Баянзүрх дүүргийн 10 -р хороо, Улиастайн гудамж 101/А тоотод “ZOOMLION-CIFA” NZS120P дугаар бүхий бүрэн автомат үйлдвэрийг 2017 оноос угсралт суурилуулалт хийн ашиглаж байгаа бөгөөд тухайн үйлдвэрлэл явуулж байгаа үйлдвэрүүд нь орчин үеийн техник, тоног төхөөрөмжөөр бүрэн тоноглогдсон, үйлдвэрлэл явуулж байгаа бүс нь нэгдсэн харуул хамгаалалттай, ашиглаж байгаа зам талбай нь тусгайлан засаж бетон хучилт хийгдсэн түүхий эдийн агуулах талбай, явган болон авто зам, тэдгээрийн гэрэлтүүлэг, машин техникийн угаалгын хэсэг зэрэг нь дэлхийн жишигт нийцсэн үйлдвэрийн бүрдэл хэсгүүд юм.

## Хоёр. Төслийн талбай, түүний орчны байгаль орчин, нийгэм-эдийн засгийн төлөв байдлын товч тодорхойлолт

Улаанбаатар хотын , Баянгол дүүрэг, 20-р хороо, Үйлдвэрийн баруун бүс /16103/, Эрчим хүчний гудамж 57/1 тоотод үйл ажиллагаагаа явуулж буй бетон зуурмагийн үйлдвэрийн Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тодотголыг 2018 онд “Гео Хэм” ХХК -р, Баянзүрх дүүргийн 10 -р хороо, Улиастайн гудамж 101/А тоотод “ZOOMLION-CIFA” NZS120P дугаар бүхий бүрэн автомат үйлдвэрийн Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тодотгол тайланг 2022 онд “Эм И Эс Зэт Би” ХХК -р хийж гүйцэтгүүлсэн бөгөөд тус матрицын үнэлгээний арга дээр тулгуурлан Олон улсын туршлагад өргөн хэрэглэгдэж буй нөлөөллийн үнэлгээний үр дагавар болон тохиолдох магадлалын шалгуур үзүүлэлтүүдийн ашиглан байгалийн бүрэлдэхүүн хэсэг тус бүрээр ангилан хийж гүйцэтгэсэн. Тус тайланд бетон зуурмагийн үйлдвэрүүд нь өөрийн эзэмшлийн талбайд үйл ажиллагаагаа явуулж байгаа бөгөөд үйлдвэрүүдийн талбай нь бүрэн хатуу хучилттай, төслийн хүрээнд ямар нэгэн барилга угсралтын үйл ажиллагаа нэмж явагдаагүй тул хөрсөн бүрхэвч болон ургамлын нөмрөгт аливаа сөрөг нөлөөлөл үзүүлэхгүй. Үүний дээр бетон зуурмагийн үйлдвэр нь Улаанбаатар хотын аж үйлдвэрийн бүсэд орших ба үйлдвэрүүдийн ахуйн бохир усаа стандартын дагуу газар доор төмөр савд цуглуулан зориулалтын техникээр соруулдаг тул зэрлэг ан амьтан болон усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл байхгүй.
Бетон зуурмагийн үйлдвэрүүдийн үйл ажиллагааны онцлогоос харахад уг үйлдвэр нь нийгэм-эдийн засагт эерэг нөлөөллүүд үзүүлдэг байна. Орчин үеийн стандартад нийцсэн, хэрэгцээнд түшиглэсэн бетон зуурмагийн үйлдвэр үйл ажиллагаа явуулснаар хэрэглэгчдэд чанартай бетон зуурмагаар хангагдах цаашлаад улс орны хөгжил, бүтээн байгуулалтанд эерэг нөлөөг үзүүлнэ.

## Гурав. Төслийн гол ба сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт

Бетон зуурмагийн үйлдвэрийн үйл ажиллагаанаас хүрээлэн буй орчинд үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл нь түүхий эдийг бункерт зөөж хийх үед тоосжилт үүсэх, ачигч болон миксер бүхий тээврийн хэрэгслээс ялгарах хорт утаа ялгарах, химийн бодисын хадгалалт, ашиглалтын явцад ууршимтгай дэгдэмхий нэгдлүүд агаарт уурших, асгарч болох зэргээр үйлдвэрийн гадаад орчны агаарын чанарт сөрөг нөлөөлөл үзүүлэх, үйлдвэрийн гадаад орчны агаарын чанар муудсанаар ажиллагсдын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх, мөн үйлдвэрийн ажилчдын авто машин болон үйлдвэрт ашиглах

химийн бодис, ачигч болон миксер бүхий тээврийн хэрэгслээс хорт утаа ялгарч агаарын чанарт сөргөөр нөлөөлж болзошгүй.

**Дөрөв. 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө, зорилт**

“Премиум Бьюлдинг Материалс” ХХК нь төслийн үйл ажиллагаанаас төсөл хэрэгжүүлж буй нутгийн байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг хамгийн бага боломжит төвшинд байлгах, байгаль орчинд үзүүлэх аливаа сөрөг нөлөөллөөс зайлсхийх, урьдчилан сэргийлэх, үүсэн бий болж болзошгүй сөрөг нөлөөллийг илрүүлэх, тэдгээрийн үр дагаврыг тогтмол хянах, хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлж ажиллана. Энэхүү байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд “Премиум Бьюлдинг Материалс” ХХК-ийн бетон зуурмагийн үйлдвэрүүдийн үйл ажиллагаанаас байгаль орчинд нөлөөлөх сөрөг нөлөөллүүдийг бууруулах арга хэмжээ, шаардагдах хөрөнгө зардал, дагаж мөрдөх дүрэм журам, стандартуудыг нэгтгэн үзүүлсэн бөгөөд төсөл хэрэгжүүлэгч тогтоогдсон гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд, тэдгээрийг арилгах бууруулах арга хэмжээний төлөвлөгөөг хянан үзэж, шинэчлэн сайжруулна. Ингэхдээ байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрүүдээс гарч буй үр дагавар, бодит байдалтай уялдуулан улам баяжуулж, сайжруулан мөрдлөг болгон ажиллана.

**ЗОРИЛТ:**

2024 онд Премиум Бьюлдинг Материалс ХХК нь бетон зуурмаг үйлдвэрлэх №1 болон №2 төсөлд дараах зорилтыг тавин ажиллана.

Үүнд:

- ISO 14001:2015 стандартын магадлан аудитыг үл тохиролгүй шалгуур үзүүлэлтийг хангах
- Бетон зуурмагт ашиглах **үнс** /fly ash/ -ний хэрэглээг нэмэгдүүлэх.
- Үйл ажиллагаанаас гарах бетон зуурмагийн хаягдлыг багасгах, бетон эдлэл хийх.
- Технологийн тээврийн хэрэгсэл угаах, зам талбай усалгаа хийх саарал усны хэрэглээг нэмэгдүүлэх.

**Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө**

Бетон зуурмагийн үйлдвэрийн байршил нь хот суурин, аж үйлдвэрийн бүсэд байрлах ба барилга угсралтын үйл ажиллагаа явагдаж дууссан тул газрын гадарга, хөрсөн бүрхэвч, ургамлын нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөлөл үзүүлэхгүй. Иймд байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хүрээнд нөхөн сэргээлтийн төлөвлөгөө боловсруулах шаардлагагүй бөгөөд төслийн хүрээнд хийгдсэн байгаа ногоон байгууламжийн арчилгааг хийж сайжруулах ажилбарыг хийж гүйцэтгэнэ.

**Дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө**

Бетон зуурмагийн үйлдвэрийн байрлаж буй нутаг дэвсгэрт амьтны аймгийн төрөл зүйл нутагшилт, шилжих хөдөлгөөн нь бүрэн алдагдсан. Үйлдвэрлэл тэр дундаа цахилгаан станц, барилгын материал зарим томоохон аж ахуйн агуулах, бетон зуурмагийн үйлдвэрүүд ихээр төвлөрсөн нутаг дэвсгэр дээр байрлаж байгаагаас гадна байгалийн унаган төрх алдагдаж экосистемд өөрчлөлт орон, шинээр барилга байгууламж улам бүр нэмэгдэхийн хирээр өнгөн хөрс хуулагдаж, ургамлын нөмрөг бүрэн алдагдаж хөрсний үржил шимт үе давхарга устаж үгүй болсон төлөв байдалтай. Энэ нутаг дэвсгэрийн хэсгүүдэд амьтны аймгаас хамгийн өргөн тархсан нь цөөн зүйлийн шувуу, шавж зэргээс үндэслэн биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө боловсруулах мөн дүйцүүлэн хамгаалах ажилбар хийх шаардлагагүй бөгөөд Премиум

Бьюлдинг Материалс ХХК -н нийгмийн хариуцлагын хүрээнд мэргэжлийн байгууллагуудтай хамтран Туул голын сав газрын шаардлагатай хэсгүүдэд нөхөн сэргээлт хийх |Богд хан уулыг ойжуулах| төслийг 2024 онд үргэлжлүүлэн хийж гүйцэтгэхээр төлөвлөгөөнд тусган оруулсан.

**Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох төлөвлөгөө**

Бетон зуурмагийн үйлдвэрийн үйл ажиллагааг явуулахад нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох үйл ажиллагаа явагдахгүй.

**Түүх, соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө**

Бетон зуурмагийн үйлдвэр нь төв суурин бүсэд үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд, хүн амын суурьшилт бий болоод удаж байгаа ба энэ хугацаанд аливаа түүх, соёлын дурсгалт зүйлс, эртний олдворууд олдсон тохиолдол байхгүй тул энэ талаар мөн тусгагдаагүй болно.

## Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

**Хүснэгт 1-1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө /2024 он/**

| Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөө | Урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ | Нийт зардал (төгрөг/1 жил) | Хэрэгжүүлэх хугацаа ба зардал-тухайн жилээр (сая төгрөг/жил) | Баримтлах стандарт, аргачлал |
|---|---|---|---|---|
| | | | 2024 | |
| Агаарын чанар | | | | |
| Бетон зуурмагт хэрэглэгдэх химийн нэмэлт бодис болон Бетон зуурмагийн хаягдлаас үүдэн гарах сөрөг нөлөөлөл үүсэх | Бетон зуурмагт хэрэглэгдэх химийн нэмэлт бодисоос хог хаягдал гарахгүй. Гарсан тохиолдолд гэрээний дагуу ханган нийлүүлэгч рүү буцаана. | - | Тухай бүр | MNS 4585:2007 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага.<br><br>MNS 5885:2008 Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ. Техникийн ерөнхий шаардлага.<br><br>Агаарын тухай хууль. 21.1, 29.1<br>Байгаль орчныг хамгаалах тухай хууль. 21.3 |
| | Бетоны хог хаягдал төлбөр | 10.000*2288₮<br>22,880,000₮ | Жилээр | |
| | Бетоны хог хаягдал тээвэрлэлт төлбөр | 10.000*7900₮<br>79,000,000 | | |
| | Химийн бодис, материалын хадгалалтын нөхцөлийн стандартыг нарийн баримталж уурших, халах, тэлэх нөхцөлөөс бүрэн сэргийлж ажиллах | - | Агуулахад химийн бодис хадгалах бүх үед | |
| СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ НИЙТ ЗАРДАЛ – 101,800,000 ₮ | | | | |

## Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

**Хүснэгт 1-2. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө /2024 он/**

| Гол ба болзошгүй сөрөг | Урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ | Нийт зардал (төг/1 жил) | Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж | Баримтлах стандарт аргачлал |
|---|---|---|---|---|
| Химийн бодис их хэмжээгээр асгарвал аюултай нөхцөл байдал үүснэ. | Болзошгүй тохиолдлоор химийн бодис асгарсан хоорондоо холилдсон тохиолдолд ашиглах стандарт шаардлага хангасан асгаралтын иж бүрдлийг байршуулах. | 2.640.000 /3*880.000/ | Жил бүр | **MNS 4968:2000** Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа. Эрүүл ахуй. Ерөнхий шаардлага. **MNS 4969:2000** Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа. Эрүүл ахуйн сургалтын зохион байгуулалт үндсэн дүрэм **MNS 5390:2004** Цахилгааны галын аюулгүй байдал. Ерөнхий шаардлага. **MNS ISO 13688:2000** Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа эрүүл ахуй. Хамгаалалтын хувцас. Ерөнхий шаардлага. **MNS 4970:2000** Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа. Өргөх, зөөх ачааны массын дээд хэмжээ. **MNS 4992:2000** Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Химийн хорт бодисын ангилал ба аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага. **MNS 5566:2005** Галын аюулаас хамгаалах. Аж ахуйн нэгж, байгууллага барилга байгууламжид гал унтраах анхан шатны багаж хэрэгслийн зайлшгүй байх шаардлага, норм. **MNS ISO 13688:2000** Хамгаалалтын хувцас ерөнхий шаардлага |
| Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, байгаль орчны дүрэм журам хэрэгжүүлэн ажиллаагүйгээс химийн бодисын нөлөөнд өртөнө | Химийн бодистой зөв харьцах, хадгалах, ашиглах талаар үйлдвэрийн ажилчдад сургалт зохион байгуулах | 800,000₮ | Жилд 1 удаа | |
| | Ажиллагсдыг эмнэлгийн үзлэгт хамруулах | 17,000,000 100*170,000₮ | Жилд 1 удаа | |
| | Ажиллагсдыг нэг бүрийн хамгаалах хувцас хэрэглэлээр бүрэн хангах | 74,000,000 100*740,000₮ | НБХХ хэрэгсэл элэгдэж муудсан тохиолдолд солих шаардлагатай. Цаашид жил бүр тооцохгүй 2-2.5 жилд тооцох | |
| Химийн бодис галд өртөж шатвал аюултай нөхцөл байдал үүснэ. | Байгаль хамгаалал, болзошгүй түймрээс урьдчилан сэргийлэх талаар ухуулга, сурталчилгааны самбар хийж байрлуулан, тухай бүрд нь шинэчилж байх. Галын хорыг зохих байршилд байрлуулах. | | Жилд 1 удаа | |
| ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ НИЙТ ЗАРДАЛ – 94,440,000 | | | | |

## Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Бетон зуурмагийн үйлдвэрийн үйл ажиллагаанаас агаарын чанарт үзүүлэх нөлөөлөл болон хөрсөнд үзүүлж буй нөлөөллүүдийг илрүүлэх, БОХМ хэрэгжилт, сөрөг нөлөөллийг бууруулах талаар авсан арга хэмжээний дүнг хянаж шалгах, цаашдын үйл ажиллагааг тодотгох зорилгоор хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт бетон зуурмагийн үйлдвэрийн гадаад орчны агаарын чанарын хяналт, хөрсөнд үзүүлж буй нөлөөлөлд шинжилгээ хийх, хугацаа, давтамж, холбогдох стандарт зэргийг тодорхойлж, хяналт шинжилгээ хийхэд гарах зардлыг тооцсон /2024 оны ОХШХ/ боловсруулан Хүснэгт 1-: 1-4 -т үзүүлэв.

**Хүснэгт 1-3. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр /агаар/**

| Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд | Хэмжих нэгж | Байршил | Нийт зардал (төг/5жил) | Хяналт шинжилгээ хийх давтамж | Баримтлах стандарт ба аргачлал |
|---|---|---|---|---|---|
| Агаарын чанарт хийх хяналт шинжилгээ | | | | | |
| Агаар дахь формальдегид болон<br>бусад органик биш нэгдэл<br>- Азотын давхар исэл, $NO_2$<br>- Озон, $O_2$<br>- Формальдегид, $CH_2O$ | мкг/мл | Үйлдвэрийн гадаад орчны агаар | 570.000 | Жилд 3 удаа | MNS 0012-068:1991 Ажлын байрны агаарт байгаа азотын<br>давхар ислийг тодорхойлох арга<br>MNS 4585:2007 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага.<br>MNS 5885:2008 Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх<br>хэм хэмжээ. Техникийн ерөнхий шаардлага.<br>MNS 3113:1981 Агаар мандал. Агаарын бохирдуулах бодисыг тодорхойлох аргад тавигдах ерөнхий шаардлага. MNS 0017-2-3-16:1988 Хот суурин газрын агаарын чанарыг хянах журам.<br>MNS 5013:2003 Бензин хөдөлгүүртэй автомашин – Утааны найрлага дахь хорт бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга<br>MNS 4585:2007 Хот, суурины агаарт химийн хорт бодис байхыг зөвшөөрөх дээд хэмжээ |
| Дэгдэмхий органик нэгдэл<br>- Бензол<br>- Трихлорэтилен<br>- Толуол<br>- П-ксилол<br>- М-ксилол<br>- Стирол<br>- 1,4- дихлорбензол<br>- 1,2- дихлорбензол | мг/л | | 510.000 | | |
| ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН НИЙТ ЗАРДАЛ-1,080,000 | | | | | |

**Хүснэгт 1-4. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр /хөрс/**

| Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд | Хэмжих нэгж | Байршил | Нийт зардал (төг/5жил) | Хяналт шинжилгээ хийх давтамж | Баримтлах стандарт ба аргачлал |
|---|---|---|---|---|---|
| Хөрсний хяналт шинжилгээ | | | | | |
| Хүнцэл (As)<br>Кобальт (Co)<br>Никель (Ni)<br>Хар тугалга (Pb)<br>Цайр (Zn)<br>Кадмий (Cd) | мг/кг | БГД-н 20, БЗД-н 10 дугаар хороо БЗҮ №1, №2 | 1.050.000 | Жилд тус бүр 3 удаа | MNS 5850:2008<br>Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ |
| ХӨРСНИЙ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН НИЙТ ЗАРДАЛ-1.050.000 | | | | | |

**Хүснэгт 1-5. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө**

| № | Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зорилт | Арга хэмжээний цар хүрээ | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | Нэгжийн зардал, төг | Нийт зардал төг | Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж | Баримтлах эрх зүйн баримт бичиг |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | Төслийн ногоон байгууламжийн урсгал зардал | Мэргэжлийн эрх бүхий байгууллага | ш | 1 га | 10,000,000 | 10,000,000 | 2024 он<br>3-10 сар | |
| 2. | Нийгмийн хариуцлагын хүрээнд ойжуулах, нөхөн сэргээх ажилбар | Мэргэжлийн эрх бүхий байгууллага | ш | 1 га | 5,000,000 | 5,000,000 | 2024 он<br>5-10 сар | |
| 3. | Нийт | | | | | 15,000,000 | | |

**БОМТ, түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх хуваарь**

Бетон зуурмагийн үйлдвэр нь жил бүр БОМТ-ний хэрэгжилтийн талаар БОАЖЯ –н ХБОБНХ –т тайлан хүргүүлэх бөгөөд хэрэгжилтийг дүгнүүлсний дараагаар байгаль орчны хяналтын улсын байцаагч, орон нутгийн байцаагч, бүх шатны Засаг дарга, байгаль орчны төрийн бус байгууллагад тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг хүргүүлнэ.

**Хүснэгт 1-4. БОМТ тайлагнах хуваарь**

| БОМТ хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх байгууллагууд | Тайлагнах, хэлэлцүүлэх хэлбэр | Мэдээллийн агуулга | Хугацааны тов | Хэлэлцүүлгээр санал авах чиглэл | Зохион байгуулах газар |
|---|---|---|---|---|---|
| Төрийн захиргааны төв байгууллага /Нийслэлийн байгаль орчны газар / | БОМТ тайланг төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний дагуу гаргаж НБОГ хүргүүлнэ. | Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тухай | Жил бүрийн 11 дүгээр сарын 10-ны дотор | Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг баталгаажуулах. | НБОГ |
| Баянгол, Баянзүрх дүүргийн Мэргэжлийн хяналтын хэлтэс | БОМТ - ний батлагдсан тайланг танилцуулах | Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тухай | Жил бүрийн 12 дугаар сарын 15-ны дотор | Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнах | БГД, БЗД МХХ |

Хууль зүйн сайдын 2016 оны
А/204 дугаар тушаалаар батлав

# МОНГОЛ УЛС
# ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

000134662

2018.01.12
/ Бүртгэсэн он,сар,өдөр /

9011720047
/ Хувийн хэргийн дугаар /

6266258
/ Регистрийн дугаар /

Премиум бьюлдинг материалс Хязгаарлагдмал хариуцлагатай компани
/ Хуулийн этгээдийн нэр, хариуцлагын хэлбэр /

Дүрэм
/ Үүсгэн байгуулах баримт бичиг /

| Тогтоол | 18/01 | 2018.01.11 |
|---|---|---|
| / шийдвэрийн нэр / | / дугаар / | / он, сар, өдөр / |

4663 Барилгын материалын худалдаа
/ код / / Үндсэн эрхлэх үйл ажиллагааны чиглэл /

4610 Гадаад худалдаа
4510 Автомашины худалдаа

/ код / / Туслах эрхлэх үйл ажиллагааны чиглэл /

| Хугацаагүй | 1 | 1,000.0 |
|---|---|---|
| / хугацаа / | / гишүүдийн тоо / | / өөрийн хөрөнгийн хэмжээ, мянган төгрөгөөр / |

Улаанбаатар, Сүхбаатар, 1-р хороо, юнеско, МПМ цогцолбор, 12 давхарт, Утас1: 88884545, Утас2: 77773311, Факс: 976-70122292
/ хуулийн этгээдийн албан ёсны хаяг /

Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газар Хуулийн этгээдийн бүртгэлийн газар
/ бүртгэсэн байгууллагын нэр /

## Хуулийн этгээдийн үүсгэн байгуулах баримт бичигт оруулсан нэмэлт өөрчлөлтийн бүртгэл

| Д/д | Нэмэлт өөрчлөлтийн агуулга | Бүртгэсэн | |
|---|---|---|---|
| | | Огноо | Ажилтан тэмдэг |
| 1 | *Адилбиш овогтой Ганболд-г Гүйцэтгэх захирал-р томилсны бүртгэв.* | *2018.01.12* | *Г.Алтай* |
| 1 | ***Өөрийн хөрөнгийн хэмжээ 7551177 мян.төг-р нэмэгдэж нийт 7552177 мян.төг болсон өөрчлөлтийг бүртгэв.*** | *2018.03.23* | *Э.Эрдэнэбилэг* |

Энэхүү гэрчилгээг хуурамчаар үйлдсэн этгээдэд Монгол Улсын хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.
Улсын бүртгэлийн гэрчилгээ засвартай бол хүчингүй.

*000134662*

0008286

# БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМ

# ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ

Дугаар МҮ 16-051/21

"Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай" Монгол Улсын хуулийг үндэслэн Улаанбаатар аймаг/нийслэлийн Баянгол сум/дүүргийн " Премиум бюльдинг материалс " ХХК -д

9011720047 /улсын бүртгэлийн дугаар/

6266258 /регистрийн дугаар/

Материалын үйлдвэрлэл: 4.2 заалтын дагуу сунгах

ажил, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг 2021 оны 06 -р сарын 08 -ны өдрөөс таван жилийн хугацаатай олгов.

Тусгай зөвшөөрөл нь хавсралт болон гэрээний хамт хүчинтэй.

**БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙД** **Б.МӨНХБААТАР**

2021 он 06 сар 08 өдөр

Улаанбаатар хот

***Ажил, үйлчилгээний төрөл:***

МҮ-4.2 Бетон зуурмагийн үйлдвэр

Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хаяг: Улаанбаатар хот, БГД, 20-р хороо
/IMER-13090171, S Couvrot-100123 MT/

Компанийн захирал /эзэн/ А.Ганболд
/овог, нэр/

Утас: 88886651 Факс: 70143311 70122292 И-мэйл: info@premiumgroup.mn

0008288

## БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМ

# ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ

Дугаар МУ 13-052/21

"Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай" Монгол Улсын хуулийг үндэслэн ........ Улаанбаатар ........ аймаг/нийслэлийн ........ Баянзүрх ........ сум/дүүргийн ........ " Премиум бюльдинг материалс " ХХК ........ -д

9011720047 ........ 6266258
*/улсын бүртгэлийн дугаар/* *|регистрийн дугаар/*

Материалын үйлдвэрлэл: 4.2 заалтын дагуу сунгах ........

........ ажил, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг 2021 оны 06 -р сарын 08 -ны өдрөөс таван ...... жилийн хугацаатай олгов.

Тусгай зөвшөөрөл нь хавсралт болон гэрээний хамт хүчинтэй.

**БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙД** **Б.МӨНХБААТАР**

2021 он 06 сар 08 өдөр

Улаанбаатар хот

***Ажил, үйлчилгээний төрөл:***

МҮ-4.2 Бетон зуурмагийн үйлдвэр

Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хаяг: Улаанбаатар хот, БЗД, 10-р хороо /IMER-13090170, TRUE MAX-516017/

Компанийн захирал /эзэн/ А.Ганболд
/овог, нэр/

Утас: 88886651 Факс: 70143311 70122292 И-мэйл: info@premiumgroup.mn

**ХИМИЙН ХОРТ БОЛОН АЮУЛТАЙ БОДИСЫГ ЭКСПОРТЛОХ, ИМПОРТЛОХ, ХИЛ ДАМЖУУЛАН ТЭЭВЭРЛЭХ, ҮЙЛДВЭРЛЭХ, АШИГЛАХ, ХУДАЛДАХ АЖ АХУЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУСГАЙ**

# ЗӨВШӨӨРӨЛ

Огноо: 2023-08-03 Дугаар: 0002512 Улаанбаатар хот

Аж ахуйн нэгжийн нэр: ПРЕМИУМ БЬЮЛДИНГ МАТЕРИАЛС ХХК
Аж ахуйн нэгжийн гэрчилгээний дугаар: 9011720047
Регистрийн дугаар: 6266258
Хаяг: Улаанбаатар, Сүхбаатар, 1-р хороо, олимпийн, 19а, Шангри-Ла төв, оффис, 23 давхарт

Утас: 88884545, 77773311

**Дараах химийн хортой, аюултай бодис:**

Импортлох, ашиглах, худалдах **тусгай зөвшөөрлийг**
2023.08.03 -2028.08.03 **хүртэл хугацаагаар олгов.**

| № | Бодисын нэр | | Томъёо | Олон улсын бүртгэлийн дугаар /CAS/ | Ангилал | Үйлдвэрлэсэн улс | Хэмжээ |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Монгол | Олон улсын | | | | | |
| 1 | Хавсралтад дурдсан 20 нэр төрөл бодис | | | | | | |
| 2 | | | | | | | |
| 3 | | | | | | | |
| 4 | | | | | | | |
| 5 | | | | | | | |
| 6 | | | | | | | |
| 7 | | | | | | | |
| 8 | | | | | | | |

**Улсын хилээр нэвтрүүлэх боомт:** Сүхбаатар, Алтанбулаг, Замын Үүд, Бичигт, Баянхошуу, Гашуунсухайт, Чингис хаан

**Зөвшөөрөл олгосон:** Байгаль орчин, аялал жуулчлалын яам
Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч / С.ЦОГТГЭРЭЛ /

Химийн хорт болон аюултай бодисын бодлого зохицуулалт хариуцсан мэргэжилтэн / Ц.БАТЖАРГАЛ /

**Химийн хорт болон аюултай бодисыг**
**Импортлох, ашиглах, худалдах 0002512**
**дугаартай тусгай зөвшөөрлийн хавсралт**

| № | Монгол нэр | Олон улсын нэр | Томъёо | CAS дугаар | Зөвшөөрсөн хэмжээ, тн |
|---|---|---|---|---|---|
| 1 | Сика Вискокрет-5500 | Sika ViskoCrete-5500 | - | 27599-56-0 | 25 |
| 2 | Сика Вискокрет-5510 | Sika ViskoCrete-5510 | - | 27599-56-0 | 9000 |
| 3 | Сика Вискокрет-5520 | Sika ViskoCrete-5520 | - | 27599-56-0 | 100 |
| 4 | Сика Вискокрет-5540 | Sika ViskoCrete-5540 | - | 27599-56-0 | 6760 |
| 5 | Сика Вискокрет-5520W | Sika ViskoCrete-5520W | - | 27599-56-0 | 100 |
| 6 | Сика Вискокрет-WR14 | Sika ViskoCrete-WR14 | - | 27599-56-0 | 100 |
| 7 | Сика Вискотайт | Sika Visko Tight | - | 27599-56-0 | 250 |
| 8 | Сика Аэр-50 | Sika Aer-50 | - | 9004-82-4 | 225 |
| 9 | Сика Рапид-1 | Sika Rapid-1 | - | 7631-99-4 | 400 |
| 10 | Силика Фюм | SikaFume | - | 7631-86-9 | 9250 |
| 11 | Сика Ретардол-25 | Sika Retardol-25 | - | 14265-44-2 | 25 |
| 12 | Сика тогтворжуулагч | Sika Stabilizer | - | 9005-84-9 | 5 |
| 13 | Сика Файбер Хүч PP44-65 | Sika Fiber Force PP 44-65 | - | 9003-07-0 | 2500 |
| 14 | Сика Тард 960HC | Sika Tard 960HC | - | 59-50-7<br>26530-20-1 | 1500 |
| 15 | Сика Памп старт 1 | Suka Pump start-1 | - | 56-81-5<br>26530-20-1 | 300 |
| 16 | Сигунит L54 AF | Sigunit L54 AF | - | - | 16000 |
| 17 | Сика UCS | Sika UCS | - | 7631-86-9<br>231-545-4 | 25 |
| 18 | Интрапласт-Z | Intraplast-Z | - | 471-34-1<br>497-19-8 | 5 |
| 19 | Пронал-753 | Pronal-753 | - | - | 1 |
| 20 | Сика Файбер Sika | Sika Fiber 3 | - | - | 15 |

МОНГОЛ УЛС

**АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ГАЗАР ЭЗЭМШИХ ЭРХИЙН**

# ГЭРЧИЛГЭЭ

**Дугаар** 000001422

Премиум бьюлдинг материалс ХХК / 6266258 /-д
*(аж ахуйн нэгж, байгууллагын нэр)* *(регистрийн дугаар)*

Дүүргийн Засаг даргын захирамж -ын 20 19 оны 01 сарын 30 өдрийн А/43 тоот
*(шийдвэр гаргагч)*

шийдвэрийг үндэслэн Улаанбаатар Баянгол 20-р хороо
*(аймаг, нийслэл)* *(сум, дүүрэг)* *(баг, хороо)*

Үйлдвэрлэлийн баруун бүс-4 /16103/ хаягт
*(гудамжны нэр)* *(хашааны дугаар/ тоот)*

байрлах, нэгж талбарын 1681900039 дугаар бүхий 39968.0 /3.9968/ м.кв /га/ газрыг

Үйлдвэрлэл зориулалтаар

2021.12.01-хүртэл жилийн хугацаатай эзэмшүүлж, эрхийн улсын бүртгэлийн Э-2205000252

дугаарт бүртгэж гэрчилгээ олгов.

**ГАЗРЫН АСУУДАЛ ЭРХЭЛСЭН БАЙГУУЛЛАГА / АЛБАН ТУШААЛТАН**

ДҮҮРГИЙН ГАЗРЫН АЛБАНЫ ДАРГА

**ТАМГА / ТЭМДЭГ** Г.МӨНХБААТАР
*(гарын үсэг)* / *(нэр)* /

5151566 1116128487

**20** 19 **оны** 03 **сарын** 07 **өдөр**

MNSPC

## ГАЗАР ЭЗЭМШИХ ЭРХИЙН ГЭРЧИЛГЭЭНИЙ ТЭМДЭГЛЭЛ

| Д/д | Нэмэлт өөрчлөлтийн агуулга | Бүртгэсэн | |
|---|---|---|---|
| | | Огноо | Ажилтан, тамга |
| 1 | | | |

Энэхүү гэрчилгээг хуурамчаар үйлдсэн этгээдэд Монгол Улсын хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ. Газар эзэмших эрхийн гэрчилгээ засвартай бол хүчингүй.

Нэгж талбарын дугаар: *1681900039*
Улсын бүртгэлийн дугаар: *Э-2205000252*
Гэрчилгээний дугаар: *000001422*

ИРГЭН, ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ГАЗАР
ЭЗЭМШҮҮЛЭХ ГЭРЭЭ

2019 оны 03 сарын 07 өдөр № 01107-2019/00253 Улаанбаатар Хот

**Нэг. Нийтлэг үндэслэл**

Монгол Улсын Газрын тухай хууль, *Улаанбаатар* аймаг /нийслэл/-ийн **Баянгол дүүрэг /сум/-ийн** Засаг даргын *2019* оны *01* сарын **30** -ны өдрийн **А/43** тоот шийдвэрийг үндэслэн газар эзэмшүүлэгчийг төлөөлж , *Улаанбаатар* аймаг/хотын **Баянгол сум/дүүргийн** Газрын албаны мэргэжилтэн *Цог* овогтой **Баярмагнай,** газар эзэмшигчийг төлөөлж **Премиум Бьюлдинг Материалс ХХК-н Гүйцэтгэх захирал Адилбиш овогтой Ганболд** нар энэхүү гэрээг байгуулав.

**Хоёр. Гэрээний нөхцөл**

2.1. Газар эзэмшигчид олгосон газрын нийт хэмжээ 39968.0 м2, 3.9968 га

Үүнээс:

| Нэгж талбарын тодорхой хэсгийг эзэмших зориулалт | Тухайн зориулалтаар эзэмших газрын хэмжээ | Газар эзэмших хугацаа |
|---|---|---|
| Үйлдвэрлэл | 39968.0 м2, 3.9968 га | 2021.12.01 хүртэл |

2.2. Газрын төлбөрийн хэмжээ:
Нэгжийн үнэ *547.0* төгрөг/үсгээр___________________________/
Газрын төлбөрөөс чөлөөлөгдөх талбай /0м$^2$/, чөлөөлөгдөх хувь /0.0%/
Бүгд үнэ *21862496* төгрөг/үсгээр______________________________/

Үүнээс:

1-р улиралд *5465624* төг
2-р улиралд *5465624* төг
3-р улиралд *5465624* төг
4-р улиралд *5465624* төг

2.3.Газрын төлбөрийг улирал бүрийн эхний сарын 25-ны дотор газар эзэмшүүлэгчийн **Улаанбаатар хоын банк дах 2602003038** тоот дансанд шилжүүлж байна.
2.4. Газар эзэмшүүлэх тухай эрх бүхий Засаг даргын шийдвэр гарсан өдрөөр газрын төлбөр хийх хугацааг тогтооно.
2.5. Эрх бүхий байгууллагын шийдвэрээр газрын төлбөрийн хэмжээ өөрчлөгдөх тохиолдолд гэрээнд өөрчлөлт оруулна. Ийнхүү газрын төлбөрийг шинэчлэн тогтоолгоогүй бол зохих зардлыг газар эзэмшигч хүлээнэ.

**Гурав. Газар эзэмшигчийн эрх**

3.1. Гэрээнд заасан зориулалтын дагуу уг газрыг эзэмших, ашиглах;

3.2. Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааг газар өмчлөгчөөс гаргуулж авах;

3.3. Газарт учирсан хохирлыг гэм буруутай этгээдээр тогтоосон журмын дагуу нөхөн төлүүлэх;

3.4.Газар эзэмшүүлэх тухай шийдвэр гаргасан этгээдийн зөвшөөрөлтэйгээр эрхийн гэрчилгээгээ бусдад шилжүүлэх, барьцаалах;

3.5. Газар эзэмшигч нь газар эзэмшүүлэх тухай шийдвэр гаргасан этгээдийн зөвшөөрөлтэйгээр тухайн газраа бүгдийг нь буюу зарим хэсгийг бусдад ашиглуулж болно.

3.6. Газрын тухай хууль тогтоомж, газар эзэмших гэрээнд заасан үүргээ зохих ёсоор биелүүлж ирсэн бол эрхийн гэрчилгээний хугацаа дуусахад уг газрыг үргэлжлүүлэн эзэмшихээр эрхийн

гэрчилгээний хугацааг сунгуулах /*Эрхийн гэрчилгээний хүчин төгөлдөр байх хугацаа дуусахаас 30-аас доошгүй хоногийн өмнө эзэмшигч нь хугацаа сунгуулах тухай хүсэлтээ тухайн шатны Засаг даргад гаргах*/;

3.7. Газар эзэмших эрхийн гэрчилгээ хүчингүй болсон тохиолдолд эрхийн гэрчилгээг хүчингүй болгосон Засаг даргын шийдвэрийг эрхийн гэрчилгээ эзэмшигч болон барьцаанд авсан этгээд нь хууль бус гэж үзвэл тухайн шийдвэр гарсан өдрөөс хойш ажлын 10 өдрийн дотор шүүхэд гомдол гаргах эрхтэй.

## Дөрөв. Газар эзэмшигчийн үүрэг

4.1. Газар эзэмших гэрээнд заасан нөхцөл, болзлыг биелүүлэх;

4.2. Газрыг үр ашигтай, зохистой ашиглах, хамгаалах, байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомж болон төрийн эрх бүхий байгууллагаас газар ашиглалттай холбогдуулан тавьсан нийтлэг шаардлагыг биелүүлэх;

4.3. Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааг тогтоосон журмын дагуу хийлгэж байх/ *5 жилд нэг удаа хийлгэнэ./*;

4.4. Бусдын газар эзэмшихтэй холбогдсон эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчихгүй байх;

4.5. Газрын төлбөрийг газрын ашигт шинж чанарыг ашигласан эсэхээс үл хамааран хугацаанд нь төлөх;

4.6. Төлбөр төлөх үүргээ хугацаандаа гүйцэтгээгүй тохиолдолд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.5 хувиар хэтэрсэн хоног тутамд алданги төлөх;

4.7. Эзэмшлийн газраа бүхэлд нь буюу зарим хэсгийг бусдад ашиглуулах бол эрх бүхий Засаг даргаас зөвшөөрөл авч, энэ тухай улсын бүртгэлд бүртгүүлэх;

4.8. Газар эзэмшүүлэгчээс газрын эзэмшил ашиглалттай холбогдуулан тавьсан шаардлагыг цаг тухайд нь биелүүлэх;

4.9. Кадастрын зураглал гүйцэтгэх эрх бүхий аж ахуйн нэгж, байгууллага, иргэнийг өөрийн эдлэн газартаа саадгүй нэвтрүүлж, ажиллах, мэдээлэл авах боломжоор хангах

4.10. Өөрийн эдлэн газрын хилийн эргэлтийн цэгүүдийг газар дээр нь тэмдэглэсэн тэмдэгтийг хамгаалалтандаа авч, бүрэн бүтэн байдлыг хариуцах

4.11. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээгээр тавигдсан шаардлагыг биелүүлэх

4.12. Эдлэн газрын эргэлтийн цэгүүдийг хөдөлгөсөн, нүүлгэн шилжүүлсэн, устгахгүй байх

4.13. Геодезийн байнгын цэг, тэмдэгт байрлаж байгаа газарт барилга байгууламж барих, газар шорооны ажил хийхдээ сум, дүүргийн Засаг дарга буюу хил хамгаалах ерөнхий газраар уламжлан геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас зөвшөөрөл авна.

4.14. Газар эзэмшүүлэх гэрээг дүгнүүлэх

4.15. Барилга байгууламжийн төлөвлөлтийн эскиз зургийг сум болон аймгийн ерөнхий архитектороор батлуулах

4.16. Барилга байгууламжийн зураг төсөл нь хот, тосгоны батлагдсан ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний шийдлүүд, олгогдсон газрын хэмжээ, зориулалттай уялдсан байх бөгөөд барилгажих талбай нь тухайн газрын 70 хувиас илүүгүй байна.

4.17. Барилгын улаан шугам тавихад Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын геодези зураг зүйн асуудал хариуцсан мэргэжилтэнг оролцуулан баталгаажуулах

4.18. Гэрээний биелэлт тооцсон дүгнэлтээр илэрсэн зөрчлүүдийг заасан хугацаанд арилгах арга хэмжээ авах

4.19 Эзэмшил, ашиглалтанд байгаа болон орчны 50м хүртэлх нийтийн эзэмшлийн зам талбай, ногоон байгууламжид тохижилт, арилчилгаа хийх

4.20. Холбогдох хууль тогтоомжоор тогтоосон бусад эрх, үүрэг, хариуцлага хүлээх;

## Тав. Газар эзэмшүүлэгчийн үүрэг

5.1. Газрыг гэрээнд заасан зориулалтын дагуу эзэмшиж байгаа эсэхийг хянах;

5.2. Уг газрыг эзэмшүүлэхийн зэрэгцээ дараахь шаардлагыг газар эзэмшигчид тавих эрхтэй. Үүнд:

а. Газрыг үр ашигтай, зохистой ашиглах, хамгаалах, байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомж болон төрийн эрх бүхий байгууллагаас газар ашиглалттай холбогдуулан тавьсан нийтлэг шаардлагыг биелүүлэх

б. Эзэмшүүлэхээр олгосон газарт зориулалтын бус барилга байгууламж барих, хүн амын амьдрах орчны чанарт сөрөг нөлөө бүхий үйл ажиллагаа явуулахгүй байх

в. Газрыг зориулалтын дагуу эрүүл ахуйн шаардлага хангаж ажиллах

г. Хот тосгоны өнгө үзэмж, эрүүл ахуйн нөхцлийг сайжруулах, газрыг хамгаалах, нөхөн сэргээх шаардлагын дагуу эзэмшилд авсан газрын 10-аас доошгүй хувийг ногоон байгууламжтай байлгана.

д. Барилгын зургийг эрх бүхий мэргэжлийн байгууллагаар хийж гүйцэтгүүлэх ба барилгыг мэргэжлийн байцаагчаар хянуулах

е. Хот байгуулалтын ерөнхий болон хэсэгчилсэн төлөвлөгөөнд өөрчлөлт орсон тохиолдолд газар эзэмших гэрээг цуцлах хүртэл арга хэмжээ авах

5.3. Газрыг гэрээний нөхцөлийн дагуу эзэмшээгүй, энэ талаар тавьсан шаардлагыг биелүүлээгүй буюу Газрын тухай хуулийн 40.1.1-40.1.6 дугаар зүйлд заасан нөхцөл бий болсон тухайлбал:

а. Эрхийн гэрчилгээ эзэмшигч газрын тухай хууль тогтоомж, газар эзэмших гэрээний нөхцөл, болзлыг удаа дараа буюу ноцтой зөрчсөн;

б. Газрыг хүн амын эрүүл мэнд, байгаль хамгаалал, үндэсний аюулгүй байдлын ашиг сонирхолд харшаар ашигласан нь эрх бүхий байгууллагын дүгнэлтээр тогтоогдсон;

в. Шилжүүлж авсан эрхийн гэрчилгээгээ улсын бүртгэлд бүртгүүлж, шинээр гэрээ байгуулаагүй;

г. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээгээр тавигдсан шаардлагыг биелүүлээгүй;

эрхийн гэрчилгээ эзэмшигч газрын төлбөрөө хугацаанд нь бүрэн төлөөгүй;

е. Хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр* гэрээнд заасан зориулалтын дагуу тухайн газраа 2 жил дараалан ашиглаагүй* зэрэг тохиолдолд гэрээг хүчингүй болгож, мөн хуулийн 62 дугаар зүйлд заасны дагуу хохирлыг нөхөн төлөхийг шаардах;

ё. Өмнөх гэрээний биелэлтээр илэрсэн зөрчлийг арилгуулах

5.4. Газар эзэмшүүлэх гэрээг жил бүр дүгнэх;

5.5. Холбогдох хууль тогтоомжоор олгогдсон бусад эрх, үүрэг, хариуцлага хүлээх;

## Зургаа. Газрын талаарх эд хөрөнгийн эрхийн зарим зохицуулалт

6.1. Газар эзэмшигчийн эзэмшилд байгаа тухайн газар дээрх үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрх өөр этгээдэд шилжвэл **газар эзэмших эрх мөн адил шилжих болно** гэж шийдвэрлэнэ.

6.2. Энэхүү гэрээгээр эзэмших газрыг хязгаартай эзэмших эрх бүхий газар ашиглагч байгаа болон ийнхүү ашиглахаар шаардсан бол түүний газар ашиглах нөхцөл, журам нь **газрын тухай хуулийн 48-р зүйлд** заасан нөхцөлийг дагаж мөрдөх болно. Шаардлагатай гэж үзвэл энэхүү гэрээнд хавсаргаж болно.

6.3. Газар эзэмшигчийн газрыг бүхэлд нь буюу зарим хэсгийг гэрээний хугацаа дуусахаас өмнө эрх бүхий байгууллага улсын тусгай хэрэгцээнд нөхөн олговортойгоор солих буюу эргүүлэн авах тухай шийдвэр гаргавал уг шийдвэрийн үндэслэл болсон талуудын урьдчилсан тохиролцоо болон бусад эрхийн актаар зохицуулна.

6.4. Гэрээний талуудын шаардлагатай гэж үзсэн бусад нөхцөл: **Эзэмших эрх бүхий газраа зориулалтын дагуу эзэмшээгүй болон газрын төлбөрөө хугацаанд нь төлж барагдуулаагүй тохиолдолд газар эзэмших эрхийг нь хүчингүй болгох хүртэл арга хэмжээ авч газар дээрх эд хөрөнгийн эрхийн асуудлыг шүүхийн журмаар шийдвэрлэнэ. Мөн зохих зөвшөөрөлгүйгээр газрын хэмжээнд өөрчлөлт оруулсан нөхцөлд газар эзэмших эрхийг цуцлах хүртэл арга хэмжээ авна.**

Жич: **"хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ..."** гэдгийг гэнэтийн давагдашгүй хүчний эсхүл байгалийн тогтолцооны өөрчлөлтөөс тухайн газарт нь эвдрэл, элэгдэл, цөлжилт бий болсон, бусдын хууль бус үйлдэл зэрэг газар эзэмшигчээс хамаарах шалтгаан байхгүй байсныг ойлгоно.

**"... зориулалтын дагуу газраа 2 жил дараалан ашиглаагүй"** гэдгийг газар эзэмшүүлэх тухай гэрээ хийгдсэнээс хойш хуанлийн бүтэн 2 жилийн дотор газар эзэмшигч нь тухайн газар дээрээ гэрээнд заасан нөхцөл, болзол, зориулалтын дагуу тодорхой үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлээгүй /барилга, байгууламж, зам талбай бариагүй, тариалан эрхлээгүй г. м/ байхыг ойлгоно.

## Долоо. Бусад зүйл

7.1. Гэрээ нь газар эзэмшигчид газрыг актаар хүлээлгэн өгч, эрх бүхий Засаг дарга газар эзэмших эрхийн гэрчилгээ олгосон өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болж мөрдөгдөнө.
7.2. Газар эзэмшүүлэх гэрээг талууд жил бүр дүгнэх ба газар эзэмшигч гэрээний биелэлтийг жил бүрийн 06-р сарын 25-ны дотор багтаан тайлагнаж, газар эзэмшүүлэгч 07-р сарын 01-ний дотор багтаан дүгнэнэ.
7.3. Газар эзэмшүүлэх гэрээг дүгнүүлээгүй, өмнөх гэрээний биелэлт тооцсон дүгнэлтээр илэрсэн зөрчлүүдийг арилгах арга хэмжээ аваагүй, дахин давтагдсан тохиолдолд Газрын тухай хууль тогтоомжийн дагуу газар эзэмших, эрхийн гэрчилгээг хүчингүй болгох саналыг холбогдох албан тушаалтанд уламжлан шийдвэрлүүлнэ.
7.4. Энэхүү гэрээтэй холбоотой бусад асуудлыг Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.
7.5. Газар олгох техникийн нөхцөл болон холбогдох мэргэжлийн байгууллагуудын дүгнэлтийн дагуу тухайн газар дээр байрлаж буй инженерийн шугам сүлжээг холбогдох байгууллагаас зөвшөөрөл авсаны үндсэн дээр нүүлгэн шилжүүлэх ба түүнтэй холбогдон гарах зардлыг газар эзэмших эрх авсан байгууллага, аж ахуйн нэгж, иргэн хариуцна.

**Гэрээний талуудын албан ёсны хаяг, харилцах утас:**

Газар эзэмшүүлэгч;
Нийслэлийн Баянгол дүүргийн газрын алба
Баянгол дүүрэг 4 дүгээр хороо, Замчдын гудамж, Дүүргийн Засаг даргын тамгын газрын шинэ байр 3 давхар

Утас: 368341, 368461

---

Газар эзэмшигч: ***Адилбиш овогтой Ганболд***
Газрын байршил: ***Улаанбаатар Баянгол 20-р хороо, Үйлдвэрлэлийн баруун бүс-4 /16103/ 57/1, 57/4***
Газар эзэмшигчийн хаяг: **Улаанбаатар, Сүхбаатар, 1-хороо, МПМ цогцолбор 12 давхарт, гудамж,**
Регистр / улсын бүртгэл /-ийн дугаар: **/6266258/**
Банк, дансны дугаар: _
Харилцах утас: 88884545, 77773311, 70122292

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

| | |
|---|---|
| Газар эзэмшүүлэгчийг төлөөлж: | Газар эзэмшигчийг төлөөлж: |
| Дүүргийн Газрын албаны дарга | Премиум Бьюлдинг Материалс ХХК-н Гүйцэтгэх захирал Адилбиш овогтой Ганболд |
| Г.Мөнхбаатар/........................../ тамга/ | /гарын үсэг/ ....................../тамга/ |
| Газар зохион байгуулагч Цог овогтой Баярмагнай | |
| гарын үсэг /......................................../ | |

Энэхүү гэрээний нэг хувийг *1681900039* дугаар бүхий нэгж талбарын хувийн хэрэгт хадгалав.

**Барилгажсан талбайн дэвсгэр газрын төлөв,**
**байдал чанарын улсын хянан баталгааны дүгнэлт**

**Хянан баталгааны төрөл :** **Захиалгат**

**1. Нэгж талбарын дугаар:** **1681900039**
**2. Иргэн, аж ахуй нэгж байгууллагын нэр:** **Премиум бьюлдинг материалс ХХК**
**3.Аймаг / нийслэл/ - .................** Улаанбаатар
**4.Сум / дүүрэг/ - ..........................** Баянгол
**Баг / хороо / - ..........................** 20-р хороо
***5. Хороолол...................................***
***6. Нийт талбай /м²/*** ***39968 м2***
**7. Хөрсний доройтол, бохирдол, түүний төрөл, зэрэглэл :**

Хөрсний өнгөн давхарга бүрэн эвдэрч бүтцээ алдаж хайрга, дайрга элсний холимог болсон. Газрын гадаргуу нилэнхүйдээ тоосжсон. Ургамал нөмрөг, байгалийн төрх бүрэн өөрчлөгдөж, хог ургамал бүхий бүлгэмдлээр солигдсон. Биологийн бохирдол байхгүй. Хотын үйлдвэрийн район учраас химийн бохирдол хотын дундаж фон түвшинээс их.

**Хөрсний хүнд металлын бохирдол**

| Газрын нэр | Үзүүлэлтийн нэр | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Хар тугалга,мг/кг | кадьми, мг/кг | зэс, мг/кг | цайр, мг/кг | никель, мг/кг | кобальт,мг/кг | хром, мг/кг |
| Баянгол дүүрэг 20-р хороо | 16.61 | 1.06 | 5.2 | - | 4.2 | - | - |
| Хүлцэх агууламж /ХА/ | 35,0 | 5,0 | 60,0 | 100,0 | 50,0 | 30,0 | 100,0 |

Үйлдвэрийн район орчмын авто зам дагуух хөрсний зэсийн агууламж хөрсний өнгөн үе давхаргадаа хамгийн бага нь 10.84 мг/кг байхад автозамаас 5-10 метрийн зайнаас авсан дээжнээс 185.10 мг/кг зэс, цайр 33.85-109.35 мг/кг байгаа нь хэвийн хэмжээнээсээ 2.5-3.5 дахин их, никель 5.65-15.15 мг/кг, хар тугалга 11.20-107.34 мг/кг байна

**8. Газар ашиглалтын аюулгүй байдал, техникийн нөхцөл**

Газар ашиглалтын аюулгүй байдалд нөлөөлөх хүчин зүйл одоогоор байхгүй. Үйлдвэрийн хашааны дундах аж ахуйн замууд эмх замбараагүй, гудамж зам төлөвлөлтгүй. Энд тэнд ахуйн болон үйлдвэрийн хог хаягдал, овоолсон шороо ихтэй.

**9. Газрын төлөв байдалд чанарын өөрчлөлтийн талаар хийсэн дүгнэлт, цаашид авах арга хэмжээний тухай зөвлөмж**

Тухайн нэгж талбарын хөрс техникийн хөлд нэрвэгдэж физик элэгдэлд нилээн орсон тул байгалийн унаган төрхөө бүрэн алдсан гэж дүгнэж болно. Үйлдвэрийн орчны авто замд тэмдэгжүүлэлт хийх. Овоолсон шороо, хог хаягдлыг зөөж тэгшлэх.

Хянан баталгааг "Цахир булан сант" ХХК-ны 2013 оны дүгнэлтийг үндэслэв.

**Газрын төлөв, байдал чанарын улсын хянан баталгааны дүгнэлт олгосон:** Баянгол дүүргийн Газрын албаны дарга

............................................... Г.Мөнхбаатар

Огноо: 2019 оны 03 дугаар сар 07

# Баянгол дүүргийн Газрын алба

Нэгж талбарын дугаар: 1681900039

Хуулийн этгээдийн нэр: Премиум Бьюлдинг Материалс ХХК Ганболд

Ашиглалтын төрөл: эзэмших

Регистрийн дугаар: 6266258

**ХАЯГ:** Аймаг/Хот: Улаанбаатар Сум/Дүүрэг: Баянгол Баг/Хороо: 20-хороо Кадастрын муж: 819

Гудамж: Үйлдвэрийн баруун бүс-16103 тоот: 57/1, 57/4




Орчны тойм:

Орчны тойм:



Масштаб = 1:25000

Координатын систем:
WGS84 / UTM 48N
EPSG: 32648

**Талбайн хэмжээ:** 39968 **квадрат метр**

Зураг хэвлэсэн: ..............................Ц.Баярмагнай
(Газар зохион байгуулагч)

Хянасан: ..............................Г.Мөнхбаатар
(Газрын албаны дарга)

000221258

Зургийн масштаб = 1:2500 (1 сантиметрт 25 метр багтана)

Хэвлэсэн огноо: 2019-03-07

КАДАСТРЫН ЗУРАГ

Нэгж талбарын дугаар: 1681900039

**ХАЯГ:** Аймаг/Хот: Улаанбаатар | Сум/Дүүрэг: Баянгол | Баг/Хороо: 20-хороо | Кадастрын муж: 819

Гудамж: Үйлдвэрийн баруун бүс-16103 | тоот: 57/1, 57/4

**Нэгж талбар**

| №. | X | Y | урт |
|---|---|---|---|
| 1 | 635843.70 | 5305668.73 | 289.13 |
| 2 | 636127.75 | 5305722.41 | 192.61 |
| 3 | 636021.36 | 5305561.90 | 180.88 |
| 4 | 635909.77 | 5305419.57 | 10.00 |
| 5 | 635901.84 | 5305425.65 | 51.85 |
| 6 | 635892.37 | 5305476.62 | 75.83 |
| 7 | 635878.54 | 5305551.16 | 24.23 |
| 8 | 635854.38 | 5305549.34 | 119.89 |

**Барилга**

| №. | X | Y | урт | Барилгын дугаар/Талбай |
|---|---|---|---|---|
| .1 | 635850.96 | 5305605.49 | 17.76 | Д.байхгүй/ 95 |
| .2 | 635849.23 | 5305623.16 | 5.27 | Д.байхгүй/ 924 |
| .3 | 635854.48 | 5305623.63 | 17.78 | Д.байхгүй/ 48 |
| .4 | 635856.32 | 5305605.95 | 5.38 | Д.байхгүй/ 111 |
| .1 | 636039.23 | 5305683.14 | 21.08 | |
| .2 | 636035.35 | 5305703.85 | 43.83 | |
| .3 | 636078.44 | 5305711.88 | 21.08 | |
| .4 | 636082.33 | 5305691.16 | 43.84 | |
| .1 | 635940.85 | 5305645.58 | 3.54 | |
| .2 | 635940.10 | 5305649.04 | 13.53 | |
| .3 | 635953.25 | 5305652.25 | 3.54 | |
| .4 | 635954.00 | 5305648.79 | 13.53 | |
| .1 | 635893.20 | 5305632.79 | 17.59 | |
| .2 | 635888.09 | 5305649.62 | 6.30 | |
| .3 | 635894.12 | 5305651.45 | 17.59 | |
| .4 | 635899.23 | 5305634.62 | 6.30 | |

КАДАСТРЫН ЗУРАГ
МОНГОЛ УЛС

**МОНГОЛ УЛС**

**АЖ АХУЙН НЭГЖИЙН ГАЗАР ЭЗЭМШИХ ЭРХИЙН**

# ГЭРЧИЛГЭЭ

**Дугаар: 0000188521**

Премиум бьюлдинг материалс — 6266258

*(аж ахуйн нэгж, байгууллагын нэр)* *(регистрийн дугаар)*

Нийслэлийн Засаг даргын захирамж 20 23 оны 05 сарын 09 өдрийн A/464 тоот

*(шийдвэр гаргагч)*

шийдвэрийг үндэслэн Улаанбаатар Баянзүрх 10-р хороо

*(аймаг, нийслэл)* *(сум, дүүрэг)* *(баг, хороо)*

Улиастай 101а хаягт

*(гудамжны нэр)* *(хашааны дугаар)*

байрлах, нэгж талбарын 1331501716 дугаар бүхий 4242 м.кв газрыг

Үйлдвэрлэлийн барилга, байгууламж, бусад газар зориулалтаар

15 жилийн хугацаатай эзэмшүүлж, эрхийн улсын бүртгэлийн Э-2204006006

дугаарт бүртгэж гэрчилгээ олгов.

Энэхүү гэрчилгээ хүчинтэй эсэхийг QR кодыг уншуулж шалгах бөгөөд гэрчилгээнд агуулагдаж буй мэдээллийг харах боломжтой.

**Хэвлэсэн огноо: 2023-05-19**

# ГАЗРЫН НЭГДМЭЛ САНГИЙН УДИРДЛАГЫН ЦАХИМ СИСТЕМ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
**ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ГАЗАР**

## НЭГЖ ТАЛБАРЫН ТОДОРХОЙЛОЛТ

Нэгж талбарын дугаар: **1331501716** (Харах)
Гэрчилгээний дугаар: **0000188521**
Гэрээний дугаар: **01110-2023/04627**

| **Газар өмчлөгч, эзэмшигч, ашиглагч иргэний мэдээлэл:** | **Нэгж талбарын мэдээлэл:** |
|---|---|
| Иргэн/хуулийн этгээдийн төрөл: **3: Монгол улсын хуулийн этгээд**<br>Регистрийн дугаар: **6266258**<br>Иргэн/хуулийн этгээдийн нэр: **Премиум бьюлдинг материалс**<br>Төрөл: **Өргөдөл гаргагч** | Эрхийн төрөл: **эзэмших**<br>Зориулалт: **Үйлдвэрлэлийн барилга, байгууламж, бусад газар**<br>Талбайн хэмжээ: **4242**<br>Гудамжны нэр:<br>Хашааны дугаар: **Улиастай** |

| **Газрын эрхийн мэдээлэл:** | **Барьцааны мэдээлэл:** | **Шүүхийн шийдвэрийн мэдээлэл:** |
|---|---|---|
| Шийдвэрийн түвшин: **Нийслэлийн Засаг даргын захирамж**<br>Шийдвэрийн огноо: **2023-05-09**<br>Шийдвэрийн дугаар: **01110-А/464/2023**<br>Улсын бүртгэлийн дугаар: **Э-2204006006**<br>Гэрээ дуусах огноо: **2038-05-09** | Барьцаалсан эсэх: Барьцаалсан<br>Чөлөөлөгдөх хугацаа: 2024-12-27 | Эрх түдгэлзүүлсэн эсэх: Үгүй |

**Үнэлгээний мэдээлэл**

| # | Газрын суурь үнэлгээний зэрэглэл /Бүс/ | Газрын суурь үнэ /1га/ | Дуудлага худалдааны анхны үнийн итгэлцүүр | Дуудлага худалдааны анхны үнэ |
|---|---|---|---|---|
| 1 | 84 \| Улаанбаатар, Баянзүрх \| 4 | 1,216,000,000₮ | 0.905 | 466,823,616₮ |
| | **Нийт:** | | | **466,823,616₮** |

**Төлбөр, татварын мэдээлэл**

| # | Төлбөр, татварын бүс | Газрын төлбөр, татварын хувь хэмжээ | Газрын төлбөр, татвар /1m2/ | Газрын төлбөр, татварын дүн |
|---|---|---|---|---|
| 1 | Улаанбаатар \| Улаанбаатар, Баянзүрх \| 4 | 0.7 | 806.000₮ | 3,419,052₮ |
| | **Нийт:** | | | **3,419,052₮** |

## НЭГЖ ТАЛБАРЫН ТҮҮХ

| Өргөдлийн төрөл | Шийдвэрийн мэдээлэл | Нэгж талбарын мэдээлэл |
|---|---|---|

# Нийслэлийн Газар зохион байгуулалтын алба

Нэгж талбарын дугаар: 1331501716 Эрхийн төрөл: эзэмших

Регистрийн дугаар: 6266258 Хуулийн этгээдийн нэр: Премиум бьюлдинг материалс

**ХАЯГ:** Аймаг/Хот: Улаанбаатар Сум/Дүүрэг: Баянзүрх Баг/Хороо: 10-р хороо Кадастрын муж: 3315

ШИНЭ: Гудамж: Улиастай Тоот: 101а ХУУЧИН: ГудамжУлиастай Тоот: 101а




Орчны тойм




Масштаб = 1: 27084

Координатын систем:

WGS84/UTM 48N

EPSG: 32648

Талбайн хэмжээ: 4242 квадрат метр

Энэхүү кадастрын зураг нь газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ болон гэрээний хамт хүчин төгөлдөр болно.

www.egazar.gov.mn

Зургийн масштаб = 1:686 (1 сантиметрт 6.86 метр багтана) Хэвлэсэн огноо: 2023-05-19

| | | |
|---|---|---|
| 9: Эзэмшиж ашиглаж буй газрын зориулалт өөрчлөх | Шийдвэрийн түвшин: **Нийслэлийн Засаг даргын захирамж**<br>Шийдвэрийн огноо: **2023-05-09**<br>Шийдвэрийн дугаар: **01110-А/464/2023** | Иргэн хуулийн этгээд: **Премиум бьюлдинг материалс**<br>Зориулалт: **Үйлдвэрлэлийн барилга, байгууламж, бусад газар**<br>Талбайн хэмжээ: **4242**<br>Гэрээ дуусах огноо: **2038-05-09** |
| 9: Эзэмшиж ашиглаж буй газрын зориулалт өөрчлөх | Шийдвэрийн түвшин: **Нийслэлийн Засаг даргын захирамж**<br>Шийдвэрийн огноо: **2023-05-09**<br>Шийдвэрийн дугаар: **01110-А/464/2023** | Иргэн хуулийн этгээд: **Премиум бьюлдинг материалс**<br>Зориулалт: **Үйлдвэрлэлийн барилга, байгууламж, бусад газар**<br>Талбайн хэмжээ: **4242**<br>Гэрээ дуусах огноо: **2035-04-13** |
| 7: Газар эзэмших эрхийг бусдад шилжүүлэх | Шийдвэрийн түвшин: **Нийслэлийн Засаг даргын захирамж**<br>Шийдвэрийн огноо: **2020-04-13**<br>Шийдвэрийн дугаар: **01110-А/498/2020** | Иргэн хуулийн этгээд: **Премиум бьюлдинг материалс**<br>Зориулалт: **Үйлдвэрлэлийн барилга, байгууламж, бусад газар**<br>Талбайн хэмжээ: **4242**<br>Гэрээ дуусах огноо: **2035-04-13** |

Хэвлэсэн огноо: 2023 оны 05 сарын 19-ны өдөр

Нэгж талбарын дугаар: 1331501716

**ХАЯГ:** Аймаг/Хот: Улаанбаатар Сум/Дүүрэг: Баянзүрх Баг/Хороо: 10-р хороо Кадастрын муж: 3315
Гудамж: Улиастай Тоот: 101а

Нэгж талбар

| № | X | Y | Урт |
|---|---|---|---|
| 1 | 651112.36 | 5308625.67 | 19.65 |
| 2 | 651093.11 | 5308621.59 | 7.28 |
| 3 | 651086.02 | 5308619.85 | 37.35 |
| 4 | 651049.73 | 5308610.81 | 71.30 |
| 5 | 651037.60 | 5308680.98 | 9.57 |
| 6 | 651047.14 | 5308681.90 | 42.42 |
| 7 | 651089.57 | 5308684.16 | 13.54 |
| 8 | 651103.10 | 5308685.07 | 28.70 |
| 9 | 651107.46 | 5308656.74 | 12.80 |
| 10 | 651109.48 | 5308644.11 | 18.69 |

Барилга

| № | X | Y | Урт | Дугаар | Талбай |
|---|---|---|---|---|---|
| Б:86.1 | 651089.42 | 5308655.22 | 11.56 | Б:86 | 431 |
| Б:86.2 | 651091.41 | 5308643.85 | 24.64 | | |
| Б:86.3 | 651067.01 | 5308640.11 | 1.31 | | |
| Б:86.4 | 651067.45 | 5308638.87 | 11.42 | | |
| Б:86.5 | 651056.28 | 5308636.42 | 13.53 | | |
| Б:86.6 | 651053.61 | 5308649.66 | 11.30 | | |
| Б:86.7 | 651064.71 | 5308651.89 | 0.98 | | |
| Б:86.8 | 651065.01 | 5308650.96 | 24.74 | | |